# ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 21 өдөр Дугаар А/26 Улаанбаатар хот

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоол, "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨҮГ-ын дүрмийн 5.5.7 дахь хэсгийн тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн баталсугай.

Зөвлөлийн дарга: Захиргааны хэлтсийн дарга

Гишүүд:
Ерөнхий нягтлан бодогч
Дотоод аудитор
Хуулийн зөвлөх бөгөөд ахлах мэргэжилтэн
Хяналтын ерөнхий инженер
Нягтлан бодогч
Үл хөдлөх хөрөнгийн ашиглалт хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Архив, бичиг хэргийн мэргэжилтэн

2. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "ДБҮЭГ" ТӨҮГ-ын захирлын 2023 оны 10 дугаар сарын 05-ны А/61 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ Б.ХАЛИУН

"Дипломат байгууллагын үйлчилгээг<br>эрхлэх газар" ТӨҮГ-ын Захирлын<br>2025 оны ..02.. дугаар сарын 21..-ны<br>өдрийн еА/26 дугаар тушаалын<br>хавсралт

АТА 373 5112303
9022031002

# "ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР" ТӨҮГ-ЫН ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 4-р заалтыг үндэслэн Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар нь /цаашид "ДБҮЭГ" гэж товчлох/ захирлын шийдвэрээр "Өмч хамгаалах байнгын зөвлөлийг /цаашид зөвлөл гэнэ/ байгуулан ажиллана. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 5 хүртэл гишүүнтэй байна.

1.2. ДБҮЭГ-ын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын болон өмч хөрөнгийн харилцааг зохицуулахтай холбогдон эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

1.4. Зөвлөл нь дотоодын хяналт хийхэд гол ажлаа чиглүүлэх бөгөөд өмч хөрөнгөтэй холбогдон гарсан хууль тогтоомж, журмын хэрэгжилт ДБҮЭГ-т хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавина.

## ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Зөвлөл нь байгууллагын өмч хөрөнгийг зөв зохистой, ариг гамтай ашиглахад байнгын хяналт тавьж, өмч хөрөнгөтэй холбогдон гарсан хууль тогтоомжийг сурталчлах, байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар байгууллагаас зохиож байгаа ажил, түүний хэрэгжилт, түүнтэй холбогдон гарч буй шийдвэрт хяналт тавина.

2.2. ДБҮЭГ-ын хагас жилийн болон жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын ажилд хяналт тавьж дүгнэлт өгнө. Шаардлагатай гэж үзвэл хяналтын тооллого хийж болно.

2.3. Байгууллагын эзэмшилд байгаа илүүдэлтэй болон элэгдэл, хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн осол гэмтлийн улмаас болон ашиглалтын шаардлага хангахгүй болон үндсэн болон эргэлтийн хөрөнгийг акталж устгах, зориулалтыг өөрчлөх, үнэ тогтоон худалдах асуудалд санал дүгнэлт гаргана.

2.4. Зөвлөлийн хурлын дүгнэлтийг үндэслэн эргэлтийн болон үндсэн хөрөнгөнд хөдөлгөөн хийх хүсэлтээ ДБҮЭГ-ын захирал Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт гаргана.
2.5. Зөвлөл нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу акталж устгах хөрөнгөнд хяналт тавьж, үнэ тогтоож худалдах, устгах ажлыг эрхлэн гүйцэтгэж энэ тухай акт үйлдэнэ.
2.6. Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн тогтооно.
2.7. Хөрөнгө оруулалтаар авсан үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтаар хийгдсэн их засварын өртөг, мөн хандив, бэлэг тусламж, төслөөр авсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлдээ тусгасан байдалд хяналт тавина.
2.8. Эвдэрсэн гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээ хангахгүй болсон, тухайн зах зээлийн үнийн жишиг ханшаас хэт өндөр үнээр авсан хэт доогуур үнээр борлуулсан үндсэн ба эргэлтийг хөрөнгийг илрүүлж, буруутай этгээдээр хохирлыг арилгуулах, зөрчил гаргасан этгээдэд арга хэмжээ авахыг байгууллагын удирдлагаас шаардах эрхтэй.
2.9. Илүүдэл ажлын байр, бусад хөрөнгийг түрээслэх эсэх, түрээсийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалт, түрээсийн байрны ашиглалтанд хяналт тавина.
2.10. Үндсэн хөрөнгийн судалгаа, тооллогын үнэн зөв эсэхэд хяналт тавина.
2.11. Зөвлөлийн аливаа шийдвэр нь ДБҮЭГ-ын захирлын тушаалаар баталгаажна.

## ГУРАВ. ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

3.1. Зөвлөл нь тухайн шаардлагатай үед хурлаа хийж, байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл, эзэмшилт ашиглалт, хадгалалт хамгаалалтын талаар дүгнэлт, хийсэн ажлынхаа талаар тайлан гаргана.
3.2. Зөвлөлийн дарга хурлын товлож, нарийн бичгийн даргаар дамжуулан бусад гишүүдэд зарлана.
3.3. Хурлыг зөвлөлийн дарга удирдах бөгөөд гишүүдийн дийлэнх олонх оролцсон нөхцөлд хүчин төгөлдөр болно.
3.4. Хурлын дүгнэлт шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар хүчин төгөлдөр болж, захирлын тушаалаар баталгаажна.
3.5. Хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй болсон гишүүн саналаа урьдчилан бичгээр өгнө.
3.6. Зөвлөлийн гишүүдийн хурлын ирцийг нарийн бичгийн дарга бүртгэж, улирал бүрийн эцэст гишүүн бүрээр хуралд оролцсон байдал, гарасан санал, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг танилцуулна.
3.7. Зөвлөл хийсэн ажил, хурлын материалаа баримтжуулсан ажлын хавтастай байна.

## ДӨРӨВ: ХАРИУЦЛАГА

4.1. Журамд заасан эрхийг хэтрүүлсэн, үндсэн хөрөнгийг данснаас хасахтай холбогдсон баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, журамд зааснаас өөр үндэслэлээр данснаас хасах дүгнэлт, санал гаргасан, өмч хөрөнгийг холбогдох тушаал шийдвэрт зааснаас өөрөөр захиран зарцуулсан, бусад этгээдэд байгууллагын өмчийг завшуулсан, хувьдаа ашиглан шамшигдуулсан буюу эдгээртэй адилтгах бусад үйлдэл хийсэн гэм буруутай албан хаагчид хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.